



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.08.01 № ЗГ-1/72
танай _____ -ны № _____ -т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08.
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.05.01 № ХЭГ/883
танай _____ -ны № _____ -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.ЭНХБАТ ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд
өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж
байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт³⁷ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.04.29 № 1/2179
танай 2024.04.24 -ны № 01/918 -т

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД Ж.ГАНБААТАР ТАНАА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



15.04.2024
15.04.2024



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,

Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>


2024.04.30 № 01/3259

танай _____-ны № _____-т

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД Ж.ГАНБААТАР ТАНАА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761001299

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС


Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

"8.ХЭЛЭЛЦСЭН нь: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2.16-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.5-д “Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.” гэж, 3.2.8-д “Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)”-ын 2.3.2.2-т “газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын таатай бодлогоор дэмжих” гэж тусгасан нь хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай¹ хуулийн дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой, найдвартай хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор газрын тос боловсруулах төрийн өмчит компанийд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талбайг давуу эрхээр олгох, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг гадаад, дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран явуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14-т “газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талбайг газрын тос боловсруулах төрийн өмчит компанийд давуу эрхээр олгох бөгөөд уг талбайд газрын тосны

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл /2021/, №09

хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 3.3-т заасан журмаар зохицуулах"-аар заасан байдаг.

Энэ хүрээнд Засгийн газрын 2021 оны 241 дүгээр тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ыг баталж, мөн оны 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст XXXI талбайг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" (МГТБҮ) ТӨХХК-д олгосон.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүд буюу гэрээлэгчид Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4-т "газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн 18.6.2, 20.1-д заасан орлого"-ын татвараас чөлөөлөгдөхөөр тусгагдсан.

Тодруулбал, албан татвар төлөгч нь 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбуунаас дээш давсан орлогод 25 хувиар төлөх татвараас чөлөөлөгдөж байна.

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нь Засгийн газраас олгосон Давст XXXI талбайд хамтран ажиллах компанийг сонгох зорилгоор холбогдох журамд нийцүүлэн 2022 оны 02 дугаар сараас 08 дугаар сарын хооронд хамтран ажиллах хүсэлтийг 19 орны 56 компанийд, мөн Монгол Улсад суугаа 13 Улсын Элчин сайдын яамдаар дамжуулан тухайн улсад газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, мэргэжлийн болон санхүүгийн чадавхтай компаниудтай хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн.

Дээрх хугацаанд "Петро Матад" ХХК, Герман-Норвегийн "Терра Эксплорэйшн-Евро Хаан" компаниудын нэгдэл, Австралийн "Жед Газ", Оросын Холбооны Улсын Роснефть, Зарубежнефть, Зарубежгеологи зэрэг 6 компани Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн өгөгдлийн сантай танилцсан боловч ямар ч компани санал ирүүлээгүй байна.

Харин үйлдвэрийн бүтээн байгуулалтын ЕРС 02, 03, 04 дүгээр багц ажлуудын ерөнхий гүйцэтгэгч Бүгд Найрамдах Энэтхэг Улсын "Мега Инженеринг Энд Инфраструктурс Лимитэд" компаниас Давст XXXI талбайд хөрөнгө оруулалт хийн, газрын тосны хайгуулыг эрчимтэй явуулж, богино хугацаанд олборлолт эхлүүлэх, цаашилбал удахгүй ашиглалтад орох газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдийн хараат байдлаас гаргахад дэмжлэг үзүүлж, урт хугацаанд хамтран ажиллах сонирхолтой байгаагаа албан ёсоор мэдэгдсэн.

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон "Мега Инженеринг Энд Инфраструктурс Лимитэд" компаниуд газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцож, гэрээний гол нөхцөлүүдийг урьдчилсан байдлаар тохиролцсон бөгөөд тус компанийн Монгол Улсад газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдхөх эрх зүйн орчин бүрдсэн нөхцөлд гэрээ байгуулах санал тавьсан. Улмаар уг

асуудал шийдвэрлэгдэхгүй тохиолдолд гэрээ байгуулах боломжгүй байгааг илэрхийлээд байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн газрын тосны олборлолт 2017 онд 1.2 сая.тн-д хүрч байсан бол сүүлийн жилүүдэд олборлолтын хэмжээгээ бууруулсаар 2023 оны олборлолтын хэмжээ 680 мян.тн орчим болсон бөгөөд газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, үйлдвэр ашиглалтад орох хугацаа ойртох тусам түүхий эдийн асуудал улам тулгамдаж байгаа тул "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн Давст XXXI талбайд явуулах газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагааг дэмжих бодит шаардлага тулгарч байна.

Иймд, иргэн, хуулийн этгээд хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг баримтлан Монгол Улсад бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил төрийн өмчит газрын тосны компанийт хамтран ажиллах этгээдийг орлогын албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь Газрын тосны тухай хууль болон Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн дагуу "Газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн үйл ажиллагаа хэвийн явагдах, түүхий эдээр тасралтгүй хангагдах боломжийг бүрдүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулагч компанийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх нехцөлийг бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгч талтай адил байхаар тогтоож үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх замаар татварын таатай орчныг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтад орох нэмэлт, 2 дугаар зүйлд хууль үйлчлэх хугацааг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Газрын тос боловсруулах үйлдвэрт Засгийн газраас олгосон Давст XXXI талбайд хөрөнгө оруулалт хийж, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй Монгол газрын тос боловсруулах үйлдвэр болон гэрээлэгчийг газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчин бүрдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар Давст XXXI талбайд гаднын хөрөнгө оруулагчтай хамтран хайгуулын ажлыг эрчимтэй явуулж, газрын тосны нөөцийн хэмжээг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн тодорхой хэсгийг өөрийн олборлосон газрын тосоор хангахад томоохон дэмжлэг болох ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж байхгүй болно.

---o0o---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан
татварын тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлэлттэй зээлээр газрын тос боловсруулах үйлдвэр (ГТБҮ) байгуулах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төслийн хүрээнд дотоодын түүхий эдэд тулгуурласан үйлдвэр байгуулагдах бөгөөд үйлдвэрийн бүтээн байгуулалт 15,9%, үйлдвэрт тос дамжуулах хоолой угсралтын ажил 38,6%-ийн гүйцэтгэлтэй байна. Төслийг амжилттай хэрэгжүүлж үйлдвэр ашиглалтад орох үед түүхий эдийн хангамж нэн тулгамдсан асуудал болох юм.

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулиар төрийн өмчит үйлдвэрт газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талбайг давуу эрхээр олгох, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг гадаад, дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран явуулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст XXXI талбайг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” /МГТБҮ/ ТӨХХХК-д олгосон бөгөөд МГТБҮ ТӨХХХК уг талбайд өмнө хийгдсэн хайгуул, судалгааны ажлын анхдагч мэдээлэл, тайлан материалыг холбогдох байгууллагаас хуулбарлан авч, геологи, геофизикийн өгөгдөл тайлал хийж, газрын тосны хэтийн төлөвт урьдчилсан байдлаар үнэлгээ хийж ажиллаж байна.

Монгол Улсад газрын тосны олборлолт 2015 онд 1.2 сая орчим тоннд хүрч байсан бол сүүлийн жилүүдэд олборлолтын хэмжээ эрс буурч 2023 онд 600.0 орчим мянган тонн газрын тос олборлосон дүнтэй байна.

Тосны голлох олборлолт хийгдэж буй Тамсаг, Тосон-Уулын ордын тосны нөөц 14,02 сая.тн болж буурах, жилийн олборлолтын хэмжээ 700.0 мянгаас 400.0 мянган тонн хүртэл буурах төлөвтэй байгаа нь үйлдвэр ашиглалтад орох үед түүхий эдийн тогтвортой хангамжид эрсдэл үүсэхээр байна.

Хөрөнгө оруулалтын зардал ихээхэн шаардах, өндөр эрсдэлтэй газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт татахаар МГТБҮ ТӨХХХК-ийн зүгээс холбогдох арга хэмжээ авч ажилласан бөгөөд Давст XXXI талбайд хөрөнгө оруулж, хамтран ажиллах тухай урилгыг олон улсын 40 гаруй компанийд хүргүүлсэн боловч санал ирүүлээгүй байна. Энэ нь Давст XXXI талбайд хөрөнгө оруулахаар сонирхож буй талтай байгуулах хөрөнгө оруулалттын гэрээ нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний нэгэн адил татвараас чөлөөлөгдөхгүй байгаатай холбоотой байна.

Газрын тосны тухай хуулийн дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүд буюу Гэрээлэгчид нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.1.4-т заасны дагуу “ногдол ашгийн орлогод 10 хувиар, жилийн орлогод 25 хувь”-иар төлөх татвараас чөлөөлөгддөг.

Түүнчлэн, Газрын тосны тухай хуулийн 4.1.14-д "бүтээгдэхүүн хуваах гэрээ" гэж энэ хуулийн хүрээнд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээг" ойлгооор заасан.

МГТБҮ ТӨХХК нь эрх зүйн хувьд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах боломжгүй учраас өөрт олгогдсон талбайд хөрөнгө оруулагчидтай бүтээгдэхүүн хуваах гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулж, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.

Иймд Засгийн газраас олгосон Давст XXXI талбайд хөрөнгө оруулалт хийж, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар ажиллаж буй МГТБҮ ТӨХХК-тай хамтран ажиллах хөрөнгө оруулагч компанийг Монгол улсад Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчин бүрдүүлэх нь зүйтэй байна.

Давст XXXI талбайд хөрөнгө оруулагчтай хамтран хайгуулын ажлыг эрчимтэй явуулснаар газрын тосны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар МГТБҮ ТӨХХК нь тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн тодорхой хэсгийг өөрийн олборлосон тосоор хангах нөхцөл бүрдэнэ гэж үзэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

-----oOo-----

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан
татварын тухай хуульд нэмэлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулиар төрийн өмчтэй компанийд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талбайг давуу эрхээр олгох, хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг гадаад, дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран явуулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Монгол Улсад газрын тосны олборлолт 2015 онд 1.2 сая орчим тоннд хүрч байсан бол сүүлийн жилүүдэд олборлолтын хэмжээ эрс буурч 2023 онд 600.0 орчим мянган тонн газрын тос олборлосон дүнтэй байна.

Газрын тосны голлох олборлолт хийгдэж буй Тамсаг, Тосон-Уулын ордын тосны нөөц 14,02 сая.тн болж буурах, жилийн олборлолтын хэмжээ 700.0 мянгаас 400.0 мянган тонн хүртэл буурах төлөвтэй байгаа нь үйлдвэр ашиглалтад орох үед түүхий эдийн тогтвортой хангамжид эрсдэл үүсч болзошгүй байна.

Газрын тосны тухай хуулиар Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгж буюу Гэрээлэгч нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.1.4-т заасны дагуу "ногдол ашгийн орлогод 10 хувиар, жилийн орлогод 25 хувь"-иар төлөх татвараас чөлөөлөгддөг.

Түүнчлэн, Газрын тосны тухай хуулийн 4.1.14-д "бүтээгдэхүүн хуваах гэрээ" гэж энэ хуулийн хүрээнд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээ" ойлгохоор заасан бөгөөд "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нь бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах боломжгүй учраас өөрт олгогдсон талбайд хөрөнгө оруулалт хийж, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах, хамтран ажиллах хөрөнгө оруулагч компанийг Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нэгэн адил Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчин бүрдүүлэх нь зүйтэй байна.

Иймд Давст XXXI талбайд хөрөнгө оруулагчтай хамтран хайгуулын ажлыг эрчимтэй явуулснаар газрын тосны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нь тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн тодорхой хэсгийг өөрийн олборлосон тосоор хангах нөхцөл бүрдэнэ. гэж үзэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

----оОо----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтын "бүтээгдэхүүн хуваах" гэсний дараа "гэрээ болон Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 5.3-т заасан" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 он
Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын¹ /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

2021 оны 01 дугээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас баталсан "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль"-иар газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тогтвортой, найдвартай хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэрийг гадаад, дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг явуулах эрхзүйн орчинг бүрдүүлсэн байна.

Газрын тосны тухай хууль болон Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулиудыг өөр хооронд нь нийцүүлэх зорилгоор Газрын тосны тухай хуулийн 7.1.14-т "газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талбайг газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэрт давуу эрхээр олгох бөгөөд уг талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 3.3-т заасан журмаар зохицуулах" гэсэн нэмэлт оруулжээ.

Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор "Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ыг баталсан бөгөөд уг журмаар төрийн өмчит компанийн газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 266 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Давст XXXI талбайг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д олгожээ. Тус компани нь уг талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалт татах талаар сүүлийн хоёр жилийн хугацаанд нэлээд арга хэмжээ авч ажилласан бөгөөд хамтран ажиллах, хөрөнгө оруулалт хийх сонирхолтой компанийтай хэлэлцээ хийх, хувь хэмжээ тохирох явцад Монгол улсад газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөх эрхэүйн орчин бүрдсэн нөхцөлд гэрээ байгуулах санал гаргасан байна.

Монгол улсад Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүд буюу гэрээлэгчид Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.1.4-т "газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн 18.6.2, 20.1-д заасан орлого"-ын татвараас чөлөөлөгдхөөр тусгагдсан байна. Өөрөөр хэлбэл, албан татвар төлөгч нь "ногдол ашигийн орлогод 10 хувь, жилийн орлогод 25 хувь"-иар төлөх татвараас чөлөөлөгдж байна.

¹Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

Иргэн, хуулийн этгээд хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг баримтлан Монгол улсад БХГ-ний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил төрийн өмчит газрын тосны компанийтай хамтран ажиллах этгээдийг орлогын албан татвараас чөлөөлөх эрхзүйн орчинг бүрдүүлэх үндэслэлтэй байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Тус хуулийн төслийн үндсэн зорилго нь газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэрийн газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр байгуулах гэрээг Газрын тосны тухай хуульд заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээний нэгэн адил үзэж, тус гэрээг байгуулсан аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлөх хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх юм.

Энэхүү хуулийг баталснаар газрын тосны хайгуулын Давст XXXI талбайд газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэр хөрөнгө оруулагчтай хамтран хайгуулын ажлыг эрчимтэй явуулснаар газрын тосны нөөцийн хэмжээг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн тодорхой хэсгийг өөрийн олборлосон газрын тосоор хангах нөхцөлийг бий болгох үр дүнд хүрнэ.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫН ЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хуулийн төсөл боловсруулах аргачлалын тавдугаарт заасны дагуу асуудлыг зохицуулах хувилбаруудыг тодорхойлж, эерэг болон сөрөг талуудыг харьцуулан доорх дүгнэлтийг гаргав.

Зохицуулалтын хувилбаруудын эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал
(Хүснэгт 1)

№	Зохицуулалтын хувилбар	Харьцуулалт		Үр дүн
		Эерэг	Сөрөг	
1	"Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхэс татгалзах;	Шийдвэрлэвэл зохих асуудал хэвээр үргэлжлэх тул тодорхой үр дүнд хүрэх боломжгүй.	Сөрөг үр дагавартай.	Сөрөг үр дүнтэй.
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх асуудал энэ зохицуулалтын хувилбарын хувьд оновчгүй буюу шаардлагагүй.	Сөрөг үр дагаваргүй.	Сөрөг үр дүнтэй.
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх асуудалд төрийн дэмжлэг шаардлагатай.	Сөрөг үр дагаваргүй.	Үр дүн өндөр.
4	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;	Монгол Улсын Үндсэн хуулиар татварын бодлого, арга хэмжээг зөвхөн УИХ-д хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг тул энэ арга нь зорилгodoо хүрэхэд тохиромжгүй	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх асуудалд төрийн бус байгууллага оролцох боломжгүй.	Үр дүнгүй.

		юм.		
5	Захиргааны шийдвэр гаргах;	Зорилгодоо хүрэх боломжгүй.	Эрх олгосон заалт байхгүй учраас Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3-т заасан шийдвэр гаргаж, зохицуулах боломжгүй.	Үр дүнгүй.
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах;	Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "татварыг зөвхөн Улсын Их Хурал" хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй" гэж заасан тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай "хууль тогтоомжийн төсөл боловсруулах" шаардлагатай байна.		Үр дүнтэй гэж үзэж байна.

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг, сөрөг талаас нь үнэлэхэд хувилбар 6 нь тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хамгийн үр дүнтэйгээр шийдвэрлэж чадах хувилбар болох нь тандан судалгаагаар тогтоогдож байна.

Иймд цаашид хувилбар 6 буюу "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбарыг үргэлжлүүлэн судлах нь зүйтэй гэж үзлээ.

ДӨРӨВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 2, 3, 4, 5-аас үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Тус хууль нь хүний эрхийн зөрчил, хүний эрхийг хязгаарласан мөн жендэрийн тэгш байдлыг зөрчих зохицуулалт агуулаагүй, тэгш хандлагатай. Жендер харгалзахгүй ажлын байр нэмэгдэнэ.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. Ялангуяа эдийн засгийн үр ашигтай нээлт хийсний дараа тухайн нээлтийг орд болгон хөгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдэх болно.

Засгийн газар олборлосон газрын тосноос газрын тосны нөөц ашигласны төлбөрийг авах учир улсын төсвийн орлого нэмэгдэнэ. Засгийн газар болон газрын

tos боловсруулах төрийн өмчит үйлдвэр нь газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд ямар нэгэн эдийн засгийн эрсдэл хүлээхгүй, харин ашиг хүртэх юм.

Ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт, нарийн технологи, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ур чадвар бүхий ажиллах хүчин шаарддаг, эрсдэл ихтэй газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, улсын төсөвт дарамт учруулахгүйгээр үйл ажиллагаа явуулах боломж бурдэнэ.

Газрын тосны нөөцийн хэмжээг есгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн тодорхой хэсгийг өөрийн олборлосон газрын тосоор хангах нөхцөл бурдэнэ.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Энэхүү хууль батлагдсанаар газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэр нь хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах боломжтой болж, газрын тосны хайгуул, ашиглалтыг хөрөнгө оруулагч талтай хамтран явуулах нөхцөл бурдэнэ.

Газрын тосны хайгуул, ашиглалтын болон энэхүү үйл ажиллагаанд оролцох бусад салбаруудад ажлын байрууд шинээр бий болно. Түүнчлэн газрын тосны хайгуулын талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа жилийн дөрвөн улиралд тасралтгүй явагдах бөгөөд ажиллах хүчиний хэрэгцээг хүнс болон бусад өргөн хэрэглээний бараагаар хангах шаардлагатай болно. Энэ нь хөдөө аж ахуйн салбар болон жижиг дунд үйлдвэрүүдэд тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай технологи, техник, тоног төхөөрөмжийг ашиглах чиглэл баримтлана. Олборлосон газрын тосоор чанар сайтай бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлнэ.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийн Зорилт 3-д “... гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана” гэж, Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.5-д “дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инноваций суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих” гэж, Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.13 дахь хэсэгт “Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжих” гэж, 2.70-д “... газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна” гэж, Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2018-2027)”-ын 2.3.2.2 “газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын таатай бодлогоор дэмжих” гэж тус тус заасантай нийцэж байна.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуультай нийцсэн бөгөөд бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй юм.

ТАВ.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх асуудлыг хуулиар шийдвэрлэхээр холбогдох хуульд заасан тул цаашид хувилбар 6 буюу "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбар болгон үргэлжлүүлэн судлах нь зүйтэй гэж үзлээ.

"Хууль тогтоомжийн төсөл боловсруулах" гэсэн зохицуулалтын хувилбар нь дэвшүүлсэн зорилгод бүрэн хүрэх боломжтой ба энэ нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээний агуулга, зарчимд нийцнэ гэж дүгнэж байна.

ДОЛОО.ЗӨВЛӨМЖ

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "... татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй" гэж заасан тул аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх тухай "хууль тогтоомжийн төсөл боловсруулах" шаардлагатай болно.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбар нь одоогийн нөхцөлд дэвшүүлсэн зорилгыг хангах хамгийн боломжит хувилбар бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь байж болох хэмжээнээс хэтрэхгүй болно.

Энэ хууль батлагдсанаар газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэртэй газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хамтран явуулах гэрээлэг Монгол улсад Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдхөө эрхзүйн орчин бүрдэх юм.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр хуулийн төсөлд шинээр заалт тусгагдахгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Аль нэг бүлэгт давуу байдал үүсгэхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Энэ нь тодорхой бүлийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш юм.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх			
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдэж буй, эсхүл хөндөгдэж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Аж ахуйн нэгжүүдэд нелөө үзүүлнэ.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Үйл ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжүүд.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэн зохицуулалт байхгүй.

	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгэрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалт тусгаагүй.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендерийн үзэл баримтлалын талаарх зохицуулалт тусгаагүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Зохицуулах харилцаа нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэхтэй холбогдох харилцаанд хамаарахгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шинэ техник, технологийг нэвтрүүлэх, нутагшуулах чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татаж, үйлдвэрлэлийн бүтцийг сайжруулах зорилготой.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн серөг нөлөө байхгүй.
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодоос олборлох газрын тосоор урт хугацаанд, найдвартай хангах нөхцөл бүрдснээр Монгол улсын газрын тосны бүтээгдэхүүний импортын хамаарлыг багасгана.
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн серөг нөлөө байхгүй.
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас	Тийм	Үгүй	Ямар нэгэн серөг нөлөө байхгүй.

	үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх			
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндэрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татна.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулснаар тодорхой хэмжээний бараа материалыг дотоодоос худалдан авна.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарагүй, зардлыг бууруулна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Шаардлага тавигдана.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Газрын тосны ордууд нээгдэж, олборлолтын үйл ажиллагаа явагдсанаар төрөл бүрийн ажлын байрууд нэмэгдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр баагасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явагдахад ажиллах хүчиний хэрэгцээнд хүнс болон бусад өргөн хэрэглээний бараагаар хангах шаардлагатай болно. Энэ нь ХАА болон жижиг дунд үйлдвэрүүдэд зерэгзэр нөлөөлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсвийн зардал нэмэгдэхгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	9.3.Төрийн байгууллагад	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.

	захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх			
10.Макро здийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалтын орчин сайжирч, эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Газрын тосны хайгуул, ашиглалтын чиглэлээр болон энэхүү үйл ажиллагаанд оролцох бусад салбаруудад ажлын байрууд шинээр бий болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой үйл ажиллагаа эрхлэгчдэд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх			
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6. Нийгмийн хамгаалал, эрүүл	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

мэнд, боловсролын систем	хүртээмжид нөлөөлөх эсэх			
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, орон нутгаас ажилчид авах зэрэг үйл ажиллагаа явагдана.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 5)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Aгаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд	Тийм	Үгүй

	агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх			үйлдвэрлэснээр агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлнө.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Газрын тос олборлох орд ашиглах үйл ажиллагаанд цахилгаан эрчим хүч шаардлагатай.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Газрын тосны дагалдах хийгээр эрчим хүч үйлдвэрлэж үйл ажиллагаанд хэрэглэнэ.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлнө.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргэөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргэөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргэөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцдөд сэргэөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Усны хэрэглээ нэмэгдэнэ.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талбай нь одоогоор ашиглагдаагүй байгаа.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Тусгай зөвшөөрлөөр хязгаарлагдах учир өөрчлөгдөхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар	Тийм	Үгүй	Ямар нэгэн сэргэг нөлөө байхгүй.

	хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх			
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Газрын тос нь нөхөн сэргээгдэхгүй баялаг.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ашиглалтыг зүй зохистой технологи ашиглан явуулна.

---Оо---

АЖ АХҮЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 он

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасан аргачлалын дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь "хуульд нэмэлт, өөрчлөлт тухай"² хэлбэрээр боловсруулагдсан байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Хуулийн тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"³-д (цаашид Аргачлал гэх) заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

- 1.1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 1.3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх;

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д⁴ заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

- 2.1. Зорилгод хүрэх байдал;
- 2.2. Ойлгомжтой байдал;
- 2.3. Харилцан уялдаа зэрэг болно.

¹ Хууль тогтоомжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

² Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг.

³ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

⁴ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 "... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно".

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Ойлгомжтой байдал:

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дарааллтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томьёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд⁵ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдүүн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг⁶ хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосоно.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал, практикт хэрэглэх боломж болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

Энэхүү шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг иргэд, байгууллага хэрхэн хүлээн авах, тэдгээрт шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг шалгадаг. Тус хуулийн төслөөр иргэд, аж ахуйн нэгжид шинээр ямар нэгэн чиг үүргийг нэмж хүлээлгэхгүй тул “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэх, хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, санхүү болон хүний нөөцийн байдал зэргийг тогтоодог. Энэ төрлийн хууль газрын тосны салбарт хэрэгжиж байсан туршлага бий бөгөөд түүний алдаа, сургамжид үндэслэн илүү нарийвчлан зохицуулахаар хуулийн төсөлд тусгагдсан байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээ

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

байгуулсан аж ахуйн нэгжүүд тус хуулийн 21.1.4-т заасан “газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон энэ хуулийн 18.6.2, 20.1-д заасан орлого”-ын татвараас чөлөөлөгдхөөр тусгагдсан байдаг. Иймд шинээр боловсруулсан хуулийн төсөлд хууль эрх тэгш үйлчлэх зарчмын дагуу газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэртэй хамтран ажиллах этгээдийг Засгийн газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн нэгэн адил хуулийн дээрх хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх зохицуулалтыг тусгасан. Иймд тус хууль батлагдсанаар практикт хэрэгжих боломж одоогийн хүчин төгөлдөр хуулийн нэгэн адил юм. Иргэн, хуулийн этгээд хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг баримтлан Монгол улсад БХГ-ний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил төрийн өмчит газрын тосны компанийтай хамтран ажиллах этгээдийг орлогын албан татвараас чөлөөлөх эрхзүйн орчинг бурдуулэх үндэслэлтэй байна.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “практикт хэрэгжих боломж” болон “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо:

Хүснэгт 1

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн тесэл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
3	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.3, 29.1.5-д болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьлоо.

Энэ дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

Хуулийн төслийн тандан судалгаа, үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл “Газрын тос боловсруулах үйлдвэрт Засгийн газраас олгосон Давст XXXI талбайд хөрөнгө оруулалт хийж, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй этгээдийг Монгол улсад Бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх эрхзүйн орчин бүрдэх” үндсэн зорилготой гэж үзэхээр байна.

Энэ зорилгын хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хувилбарыг сонгожээ.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр “газрын тосны салбарын бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу болон газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэртэй байгуулсан гэрээний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.2, 20.1-д заасан орлого”-ыг албан татвараас чөлөөлөхөөр зохицуулсан байна.

Дээрх зохицуулалтаас үзэхэд хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэртэй хамтран ажиллах этгээдийг Засгийн газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан бусад аж ахуйн нэгжүүдийн нэгэн адил татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, ингэснээр газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрчимжих, үүнийг дагаад нөөц, улмаар олборлолтын хэмжээ нэмэгдэх зорилтыг хангах зохицуулалтыг бүрэн тусгасан гэж үзэж болохоор байна.

2. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд тавигдсан шаардлагыг хангасан эсэх асуудлын хүрээнд авч үзлээ.

Энэхүү хуулийн төслийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн

24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх хэсэгт “бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу” гэснийг “бүтээгдэхүүн хуваах гэрээ болон газрын тос боловсруулах төрийн өмчтэй үйлдвэртэй байгуулсан гэрээний дагуу” гэж өөрчлөхөөр тусгасан нь нэгэн төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд татварын ижил эрх зүйн орчинд ажиллах боломжийг бүрдүүлэхээр байна.

Хуулийн төсөл нь хуулийн төслийн бүтэц, эх бичвэрийн агуулгад тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна, мөн хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын нийтлэг шаардлагад нийцсэн байна.

3. Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.3, 29.1.5-д болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан
шаардлагыг хангасан эсэх:

Хүснэгт 2

№	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Үндсэн хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан зарчмыг хангахад чиглэсэн байна.
2	29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Харилцаанд орж байгаа талуудад эрх тэгш хууль эрх зүйн нөхцлийг бий болгож байна гэж үзэж байна.
3	29.1.5. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь хуулийн бусад заалтуудтай зөрчилдөөгүй байна.

Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

Хүснэгт 3

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь бусад хуультай зөрчилгүй байна.
2	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төслийн зорилгод хүрэх зохицуулалтыг сонгосон тул ямар нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагагүй.
3	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд иргэдийн эрхийг хязгаарласан ямар нэгэн нэмэлт зохицуулалт тусгагдаагүй, харин аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зохицуулалт тусгагдсан.
4	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Ямар нэг зохицуулалтыг тусгах шаардлагагүй.
5	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
6	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Хуулийн зохих заалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиар зохицуулсан тул уг хуулийн төсөлд тухайлан тусгах шаардлагагүй юм.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон бусад хуулийн холбогдох зохицуулалттай зөрчилдсөн, иргэний эрхийг зөрчсөн, хязгаарласан, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалти nuudyн чиг үүрэгт давхардал үүсгэсэн агуулга тусгагдаагүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нэлөө тооцох үнэлгээг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүний үзэл баримтлалд тулгуурлан хийллээ.

Хуулийн төсөл нь дэвшиүүлсэн зорилгоо хангасан эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур

үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах **Дүгнэлтийг хийж, Зөвлөмж боловсрууллаа:**

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангах боломжтой. Иймд зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг нэмж тусгах шаардлагагүй гэж үзлээ.

Ойлгомжтой байдал: Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хэлбэр, агуулгын хувьд хангасан байна.

Харилцан уялдааг хангасан байдал: Хуулийн төслийн зүйл заалт нь холбогдох бусад хуулийн зохицуулалттай зөрчилдсөн, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгэхээргүй байна.

Зөвлөмж:

Хуулийн төслийн үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан хуулийн төслийн зохицуулалтыг хасах, нэмэх, өөрчлөх, тодруулах шаардлагагүй гэж үзлээ.

---00---

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦОО

2024 он

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

1.Хуулийн этгээдийн зардал

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай 21.1.4 дүгээр зүйлд “бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу” гэснийг “бүтээгдэхүүн хуваах гэрээ болон газрын тос боловсруулах төрийн өмчит үйлдвэртэй байгуулсан гэрээний дагуу” гэж нэмж өөрчлөхөөр хуулийг төслийг боловсруулсан байна.

Дээрх хуулийн төслөөр хуулийн этгээдэд тусгайлан үүрэг хүлээлгэсэн, нэмэлт ачаалал үүсгэх зохицуулалт тусгаагүй байна. Иймд хуулийн төслөөр хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгээгүй байх тул хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоог цааш үргэлжлүүлэн шалгах шаардлагагүй буюу хуулийн этгээдэд шинээр үүсэх зардал болон ачаалал байхгүй байна.

2.Иргэнд үүсэх зардал

Хуулийн төслөөс харахад иргэнд тусгайлан үүрэг хүлээлгэсэн, нэмэлт ачаалал үүсгэх зохицуулалт тусгаагүй байна. Иймд хуулийн төслөөр иргэнд шинээр ямар нэг үүрэг хүлээлгээгүй байх тул иргэнд үүсэх зардлын тооцоог цааш үргэлжлүүлэн шалгах шаардлагагүй буюу иргэнд шинээр үүсэх зардал болон ачаалал байхгүй байна.

3.Төрийн байгууллагад үүсэх зардал

Хуулийн төслөөр төрийн байгууллагад шинээр тусгайлан үүрэг хүлээлгээгүй байх тул төрд үүсэх зардлын тооцоог цааш үргэлжлүүлэн шалгах шаардлагагүй буюу хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын төсөвт ачаалал үүсэхгүй. Мөн төрийн байгууллагад шинээр чиг үүрэг нэмэгдэхээргүй байна.

Дүгнэлт

Аргачлалын дагуу “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулан өөрчлөн найруулах талаарх энэхүү хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр аливаа иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт орохгүй, шинээр үүсэн гарах ачаалал, зардал байхгүй болно.

---оо---

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Монгол Улсын сайд. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан,
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар,
3. Сангийн сайд Б.Жавхлан,
4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа,
5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр,
6. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг.